



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2015 оны 4 сарын 01 өдөр

Дугаар А-5Р

Улаанбаатар хот

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод
хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 69 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50.0 (тавин) тэрбум төгрөгөөр тогтоосугай.

2.Одоо үйл ажиллагаа эрхэлж буй банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг банкуудын хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай. Үүнд:

а.2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл ногдол ашиг хуваарилахгүй байх;

б.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллах төлөвлөгөөг боловсруулан Монголбанкинд 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэх.

4.Энэ тушаалын 3.б дэх хэсэгт заасны дагуу банкуудаас ирүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллах төлөвлөгөөг үндэслэн авах арга хэмжээний санал боловсруулахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганбат)-т үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганбат)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14 0496